



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 04 өдөр

Дугаар A/73

Улаанбаатар хот

**Спорт цогцолборын үнэ тарифыг
шинэчлэн батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Спорт цогцолборын ажиллах журам”-д заасны дагуу гадны байгууллага болон хувь хүмүүст түрээслүүлэх 1 цагийн түрээсийг 90,000 (ерэн мянга) төгрөгөөр, тэмцээний түрээсийг 1,000,000 (нэг сая) төгрөгөөр тус тус шинэчлэн баталж, 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс мөрдөж ажилласугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн A/78 тоот тушаалаар батлагдсан “Спорт цогцолборын ажиллах журам”-ын 8.1 дэх заалтыг хүчингүйд тооцсугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтэс (Ц.Азжаргал), Захиргаа удирдлагын хэлтэс (Г.Мөнгөнцэцэг)-т тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.МИНЖИНХҮҮ